

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТОВЧ ТАЙЛАН

2026.06.10

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2026 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

/Хэрэгжилтийн дэлгэрэнгүйг хүснэгт 1/

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
5	4	1	-	-	-	94%

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжиж буй 1 арга хэмжээ:

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 25 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-05-28 Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийн төсөвт өөрчлөлт оруулах талаар Хятадын талаас ирүүлсэн саналыг судалж, хэлэлцээр хийх замаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлж шийдвэрлэхийг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (У.Бямбасүрэн), “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Артур), “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн гүйцэтгэх удирдлага (Б.Дүгэржав) нарт даалгав.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 03/2549 дүгээр албан бичгээр “Тавантолгой төмөр зам” ХХК-д төсөвт өртгийг дахин боловсруулж, эрх бүхий байгууллагаар магадлуулах үүрэг өгсөн. Үүний дагуу төсөвт өртгийг шинэчлэн боловсруулж, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 126/2025 дугаар Магадлалын ерөнхий дүгнэлтээр

магадлуулсан. Зам, тээврийн сайдын 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 01/3691 дүгээр албан бичгээр төслийн өртгийг бууруулах чиглэл өгсний дагуу төсөвт өртгийг дахин боловсруулж, 2025 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 208/2025 дугаар Магадлалын ерөнхий дүгнэлтээр магадлуулсан.

Төсөвт өртөгтэй холбоотой асуудлыг Зам, тээврийн сайдын 2025 оны А/207 дугаар тушаалаар болон Ерөнхий сайдын 2025 оны №50, 2026 оны №102 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгүүдэд тус тус танилцуулсан. Ажлын хэсгүүдийн шийдвэрээр “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам”-ын бүтээн байгуулалтын ажлын явц, санхүүжилтийн асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэхээр болсон./Хэрэгжилт 70%/

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

2026 оны эхний хагас жилийн байдлаар Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн 4 заалт бүрэн хэрэгжиж 100%, 1 заалт хэрэгжих шатандаа 70%, хэрэгжилтийн дундаж үнэлгээ 94%-тай байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

1) “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам”-ын төслийн төсөвт өртгийн өөрчлөлттэй холбоотой асуудлыг холбогдох байгууллагуудтай үргэлжлүүлэн зөвшилцөж, Засгийн газрын хуралдаанд танилцуулан эцэслэн шийдвэрлүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах.

2) Засгийн газрын өгсөн үүрэг, чиглэлийн хэрэгжилтийг эрчимжүүлж, төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой санхүүжилт, төсөвт өртгийн асуудлыг эцэслэн шийдвэрлүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.

Хавсралт 4 хуудастай.

ТАНИЛЦСАН:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

ТӨСӨЛ, СУДАЛГААНЫ
ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН БИЧСЭН:
ХШҮДАА-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ХАРИУЦСАН АУДИТОР



Х.ПҮРЭВЖАРГАЛ

Б.ЭНХБААТАР



Б.МЯГМАРЖАВ

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК
(2026 оны эхний хагас жилийн байдлаар)

2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр

Хүснэгт 1

№	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Хувь
Засгийн газрын тогтоол				
1	Төмөр замын барилгын ажлын зөвшөөрөл олгох тухай 2025-03-26 Дугаар 2025_156	2. “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам”-ын суурь бүтцийн барилгын ажлыг 2025 оны 05 дугаар сард багтаан эхлүүлэхийг “Тавантолгой төмөр зам” ХХК (Б.Дүгэржав), “Эрдэнэс Тавантолгой” ХК (Х.Мөнхжаргал)-д даалгаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайханд үүрэг болгосугай. /Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын зөвшөөрлийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д 5 (таван) жилийн хугацаатай олгосугай/	“Гашуунсухайт - Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам”-ын төслийн барилга угсралтын ажил 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдөр гүүрийн тулгуурын анхны өрөмдлөгийн ажлыг эхлүүлж, 07 дугаар сарын 07-ны өдөр барилга угсралтын ажлын үндсэн суурь болох геодезийн гурван хэмжээст байрлал, өндрийн хатуу цэгүүдийг төслийн Ерөнхий гүйцэтгэгчид хүлээлгэн өгч, барилга угсралтын ажил 2025 оны 07 дугаар сарын 15-ны өдөр эхэлж, 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар нийт 31.52%-ийн гүйцэтгэлтэй байна. Багц ажил тус бүрээр харуулбал: Багц 1. Дээд, доод бүтэц -5.09%; Багц 2. Урт гүүр - 25.017%; Багц 3. Эрчим хүч - 0.05%; Багц 4. Барилга байгууламж - 1.35%; Багц 5. Дохиолол, холбоо - 0.00%; Багц 6. Авто зам - 0.01%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна.	100%
2	Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын	1. 1.Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхтэй	Монгол Улсын Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны даргын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/30 дугаар тушаалаар “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам”-ын барилгын бүсэд техник, тоног төхөөрөмж, барилгын болон	100%

	бүтээн байгуулалтын хаалттай бүс байгуулах тухай 2025-03-26 Дугаар 2025_15	холбогдуулан улсын хилийн зурваст бүтээн байгуулалтын хаалттай бүс байгуулах асуудлыг шийдвэрлэхийг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн), Гадаадын иргэн, харьяатын газар (Н.Ууганбаяр), Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Энхбат, "Тавантолгой төмөр зам" ХХК (Б.Дүгэржав)-д даалгасугай.	өдөр тутмын бараа материалыг улсын хилээр нэвтрүүлэх зохицуулалт хийх, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талтай ажлын уялдаа холбоог хангах, бүтээн байгуулалтын ажилд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг БНХАУ-ын талтай уулзалт хийж "Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт–Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хаалттай бүсэд мөрдөх түр журам"-ын төслийг боловсруулсан. Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн "Түр журам болон солбицол батлах тухай" 69 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт–Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хаалттай бүсийн солбицол"-ыг, 2 дугаар хавсралтаар "Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт–Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хаалттай бүсэд мөрдөх түр журам"-ыг тус тус баталсан. Уг түр журмын хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Зам, тээврийн сайдаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
3	Гэрээний жишиг нөхцөл хэрэглэх тухай 2025-04-09 Дугаар 2025_176	1. Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын барилгын ажлын гүйцэтгэгчийн тендер шалгаруулалт болон барилгын ажил гүйцэтгэх гэрээнд Олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо (FIDIC)-Hbi гэрээний жишиг нөхцөлийг тусгаж хэрэгжүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн	"Гашуунсухайт–Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам"-ын бүтээн байгуулалтын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог Төрийн худалдан авах ажиллагааны газарт байгуулсан. Төслийн тендерийг 2025 оны 04 дүгээр сарын 01-нд зарлаж, 04 дүгээр сарын 30-нд нээсэн бөгөөд гүйцэтгэгчээр БНХАУ-ын "Төмөр замын барилгын гүүрийн инженерийн товчоо групп" компани шалгарсан. "Тавантолгой төмөр зам" ХХК болон БНХАУ-ын "Төмөр замын барилгын гүүрийн инженерийн товчоо групп" 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо (FIDIC)-ийн Hbi /2017 оны улаан ном/-ын жишиг нөхцөлийг үндэслэн "Гашуунсухайт–Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын барилга угсралтын ажил гүйцэтгэх ерөнхий гэрээ"-г байгуулсан.	100%

		дагуу зохион байгуулж ажиллахыг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Төрийн худалдан авах ажиллагааны газар (Ц.Батзул), “Эрдэнэс Тавантолгой” ХК (Х.Мөнхжаргал), “Тавантолгой төмөр зам” ХХК (Б.Дүгэржав)-д даалгасугай		
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл				
1	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 10 дугаар тэмдэглэл 2024-03-13 Дугаар 2024_10	13.6.2. “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам”-ын барилга угсралтын ажлын гэрээг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан зохих журмын дагуу байгуулах арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, “Эрдэнэс Тавантолгой” ХК дахь Засгийн газрын Онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Будбаяр нарт, төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг мөн оны 2 дугаар улиралд багтаан эхлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Будбаяр нарт тус тус даалгав;	“Гашуунсухайт–Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам”-ын бүтээн байгуулалтын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог Төрийн худалдан авах ажиллагааны газарт байгуулсан. Тендерийг 2025 оны 04 дүгээр сарын 01-нд зарлаж, 04 дүгээр сарын 30-нд нээсэн бөгөөд гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Төмөр замын барилгын гүүрийн инженерийн товчоо групп” компани шалгарсан. Төслийн барилга угсралтын ажил 2025 оны 06 дугаар сарын 15-нд гүүрийн тулгуурын анхны өрөмдлөгийн ажлыг эхлүүлж, 07 дугаар сарын 07-нд барилга угсралтын ажлын үндсэн суурь болох геодезийн гурван хэмжээст байрлал, өндрийн хатуу цэгүүдийг төслийн ерөнхий гүйцэтгэгчид хүлээлгэн өгч 07 дугаар сарын 15-нд албан ёсоор эхэлсэн. 2026 оны 06 дугаар сарын 08-ны байдлаар нийт гүйцэтгэл 31.52% байна. Багц ажлуудын явц: Багц 1. Дээд, доод бүтэц -5.09%; Багц 2. Урт гүүр - 25.017%; Багц 3. Эрчим хүч - 0.05%; Багц 4. Барилга байгууламж - 1.35%; Багц 5. Дохиолол, холбоо - 0.00%; Багц 6. Авто зам - 0.01%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна.	100%

2	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 25 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-05-28 Дугаар 2025_25	25.31.3. “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам”-ын төслийн төсөвт өөрчлөлт оруулах талаар Хятадын талаас ирүүлсэн саналыг судалж, хэлэлцээр хийх замаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлж шийдвэрлэхийг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (У.Бямбасүрэн), “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Артуур), “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн гүйцэтгэх удирдлага (Б.Дүгэржав) нарт даалгав.”	Монгол Улсын Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 03/2549 дүгээр албан бичгээр “Тавантолгой төмөр зам” ХХК-д төсөвт өртгийг дахин боловсруулж, эрх бүхий байгууллагаар магадлуулах үүрэг өгсөн. Үүний дагуу төсөвт өртгийг шинэчлэн боловсруулж, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 126/2025 дугаар Магадлалын ерөнхий дүгнэлтээр магадлуулсан. Зам, тээврийн сайдын 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 01/3691 дүгээр албан бичгээр төслийн өртгийг бууруулах чиглэл өгсний дагуу төсөвт өртгийг дахин боловсруулж, 2025 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 208/2025 дугаар Магадлалын ерөнхий дүгнэлтээр магадлуулсан. Төсөвт өртөгтэй холбоотой асуудлыг Зам, тээврийн сайдын 2025 оны А/207 дугаар тушаалаар болон Ерөнхий сайдын 2025 оны №50, 2026 оны №102 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгүүдэд тус тус танилцуулсан. Ажлын хэсгүүдийн шийдвэрээр “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам”-ын бүтээн байгуулалтын ажлын явц, санхүүжилтийн асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэхээр болсон.	70%
---	--	--	--	-----